



# ДОРНОГОВЬ АЙМГИЙН СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС

Дорноговь аймгийн  
нийгэм, эдийн засгийн  
танилцуулга

## ДОРНОГОВЬ АЙМГИЙН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН ТАНИЛЦУУЛГА

### 2019/10



Мэдээллийн нэгдсэн лавлах: [WWW.1212.MN](http://WWW.1212.MN)

## ГАРЧИГ

Товч танилцуулга.....	1-15
Нийгэм, эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүд.....	16
Нэг. Эрүүл мэнд.....	17-18
Хоёр. Хөдөлмөр эрхлэлт .....	19-21
Гурав. Нийгмийн даатгал, халамж.....	22-25
Дөрөв. Гэмт хэрэг.....	26-27
Тав. Мөнгө,зээл .....	28
Зургаа. Төсөв, санхүү .....	29-30
Долоо. Үнэ.....	31-34
Найм. Хөдөө аж ахуй .....	35-37
Ес. Аж үйлдвэр.....	38-42
Арав Барилга .....	43-45
Арван нэг. Байгаль орчин .....	46

## **ДОРНОГОВЬ АЙМГИЙН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН БАЙДАЛ**

( 2019 оны 10 дугаар сарын байдлаар)

### **Нэг. Нийгмийн үзүүлэлт**




#### **1.1 Хүн ам**

Дорноговь аймгийн хэмжээнд 2019 оны 10 сард 1096 эх амаржиж, 1100 хүүхэд шинээр мэндэлж, 328 хүн нас барсан байна. Амаржсан эхийн тоо өмнөх оны мөн үеэс 38(3.4%)-аар, төрсөн хүүхдийн тоо өмнөх оны мөн үеэс 61(5.7%)-ээр буурч, нас барсан хүний тоо өмнөх оны мөн үеэс 41(14.2%)-ээр тус тус өсчээ.

Хүн амын цэвэр өсөлт 809 болж 2018 оны мөн үеийнхээс 20(2.5%)-оор өссөн байна. 1000 хүнд ногдох төрөлт 11.7, нас баралт 4.8 байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад төрөлт 4.2 пунктээр буурч, нас баралт 0.5 пунктээр өссөн байна.

*Зураг. Төрсөн хүүхэд, нас барсан хүний тоо. 2016-2019 оны 10 сард*



Он гарсаар эхийн эндэгдэл гараагүй бөгөөд нялхсын эндэгдэл 7 байна.



#### **1.2 Эрүүл мэнд**

2019 оны 10 сарын байдлаар 336.9 мянган хүнд амбулаторийн үзлэг хийсэн нь өмнөх оны мөн үеэс 12.6 хувиар, 11.4 мянган хүн урьдчилан сэргийлэх тарилгад хамрагдсан нь өмнөх оны мөн үеэс 1.8 хувиар, 14.0 мянган хүн эмнэлэгт хэвтэж эмчлүүлсэн нь өмнөх оны мөн үеэс 1.4 хувиар тус тус өссөн байна.


2019 оны 10 сард 1537 эх жирэмсний хяналтанд орсны 89.1 хувь буюу 1369 эх жирэмсний эхний 3-н сард хяналтанд хамрагджээ. Жирэмсний хяналтанд хугацаандаа орсон эхийн эзлэх хувь өмнөх оны мөн үетэй адил хэмжээнд байна.

Түргэн тусламжийн дуудлага 16.2 мянган удаа гарсны 2.5 мянга буюу 15.4 хувь нь алсын дуудлага байв. Өмнөх оны мөн үетэй харьцуулбал нийт түргэн

тусламжийн дуудлага өмнөх оны мөн үеэс 0.6 хувиар, алсын дуудлага өмнөх оны мөн үеэс 7.4 хувиар тус тус буурсан байна.

Он гарсаар ослын улмаас 2850 хүн бэртэж, 74 иргэний амь нас энджээ. Өмнөх оны мөн үетэй харьцуулбал бэртэж гэмтсэн хүний тоо 230(8.8%)-аар өсч, нас барсан хүний тоо 7(8.6%)-өөр тус тус буурчээ.

*Зураг. Нас баралт, өвчний шалтгаанаар, хувь. 2019 оны 10 сард*



Нас баралтыг өвчний шалтгаанаар авч үзэхэд хавдар 23.2 хувь, цусны эргэлтийн тогтолцооны өвчин 25.0 хувь, осол гэмтэл, хордлого гадны шалтгаант үхэл 22.6 хувь, бусад төрлийн өвчин 14.3 хувь, амьсгалын тогтолцооны өвчин 8.2 хувь, хоол шингээх эрхтний өвчин 6.7 хувийг тус тус эзэлж байна.

Халдварт өвчний 865 тохиолдол бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 278-аар буюу 47.4 хувиар өсчээ. Халдварт өвчний тохиолдол өсөхөд тэмбүү 56.1 хувь, заг хүйтэн 64.0 хувь, трихоминиаз 2 дахин өссөн нь голлон нөлөөлжээ.




#### 1.4 Бүртгэлтэй ажилгүй иргэн

Хөдөлмөрийн хэлтэст ажил хайж бүртгүүлсэн иргэд 2019 оны 10 сарын эцэст 533 болсны 470(88.2%) нь бүртгэлтэй ажилгүй иргэд, 90(16.8%) нь шилжин суурьшсан иргэд байна.

Нийт бүртгэлтэй ажилгүй иргэд нь өмнөх оны мөн үеийнхээс 483(47.5%) хүнээр, өмнөх сараас 63(13.4%) хүнээр тус тус буурчээ.

Бүртгэлтэй ажилгүй иргэдийн боловсролын түвшинг харахад 395(74.1%) нь бүрэн дунд, 62(11.6%) нь дээд, 34(6.4%) нь бүрэн бус дунд, 12(2.3%) нь техник болон мэргэжлийн, 12(2.3%) нь тусгай дунд, 13(2.4%) нь боловсролгүй, 1(0.2%) нь магистр, 4(0.8%) нь бага боловсролтой иргэд эзэлж байна.


Зураг. Ажилгүй иргэдийн тоо, боловсролоор, хувиар, 2019 оны 10 сарын эцэст



Хөдөлмөрийн хэлтэст 2019 оны 10 сарын эцэст 325 иргэн шинэ ажлын байранд орж, бүртгэлтэй байсан 91 иргэн ажилд зуучлагдан орж, 113 иргэн ажил идэвхтэй хайхгүй байгаа шалтгаанаар бүртгэлээс хасагдсан байна.

Хөдөлмөрийн хэлтэст ирсэн 516 ажлын байрны 179(34.7%) нь энгийн ажил, 71(13.8%) нь техникч болон туслах /дэд мэргэжилтэн, 70(13.5%) нь суурин төхөөрөмж, машин механизмын операторч, угсрагч, 60 (11.6%) нь мэргэжилтэн, 54 (10.4%) үйлдвэрлэл, барилга, гар урлал,холбогдох ажил үйлчилгээний ажилтан, 26(5.0%) нь контор үйлчилгээний ажилтан, 24(4.6%) нь худалдаа, үйлчилгээний ажилтан, 15(2.9%) нь ХАА, ой, загас агнуурын ажилтан, 17(3.8%) бусад салбарын ажлын байрны захиалга байна.

Зураг. Бүртгэлгүй ажилгүй иргэд сумаар






### 1.5 Нийгмийн даатгал, халамж

Нийгмийн даатгалын хэлтсийн мэдээллээр нийгмийн даатгалын сангийн орлого 2019 оны 10 сарын байдлаар 33849.3 сая төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 7181.4 (26.9%) сая төгрөгөөр өссөн байна. Нийгмийн даатгалын сангийн орлого 2019 оны 10 сард өмнөх оны мөн үеэс 7181.4 сая төгрөгөөр нэмэгдэхэд тэтгэврийн даатгал 4599.9 (27.4%) сая төгрөг, эрүүл мэндийн даатгал 1092.7 (24.7%), ҮОМШӨ-ний даатгал 758.9 (27.3%) сая төгрөг, тэтгэмжийн даатгал 521.0 (27.4%) сая төгрөг, ажилгүйдлийн даатгал 208.9 (27.1%) сая төгрөгөөр өссөн байна.

*Зураг. Нийгмийн даатгалын сангийн орлого сангийн төрлөөр /сая.төг/ 2019 оны 10 сард*



Нийгмийн даатгалын сангийн зарлага 41677.1 сая.төг болж өмнөх оны мөн үеэс 4482.3(12.1%) сая.төгөөр өссөн байна. Зарлагыг бүтцээр нь авч үзвэл тэтгэврийн даатгалын сангаас 31210.8 (74.9%) сая.төг, эрүүл мэндийн даатгалын сангаас 4689.2 (11.3%) сая.төг, тэтгэмжийн даатгалын сангаас 2466.3 (5.9%) сая.төг, ҮОМШӨ-ний даатгалын сангаас 2409.6 (5.8%) сая.төг, тэтгэмжийн даатгалын сангаас 2466.3 (5.9%) сая.төг, ажилгүйдлийн даатгалын сангаас 901.2 (2.2%) сая төгрөгийг зарцуулжээ.


Зураг. Нийгмийн даатгалын сангийн орлого, зарлага, сая төг




Хөдөлмөр, халамж үйлчилгээний газрын мэдээллээр нийгмийн халамжийн сангаас 2019 оны 10 сард нийгмийн халамжийн сангаас 24580 иргэнд 7008.4 сая төгрөгийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж олгожээ. Өмнөх онтой харьцуулахад халамж авсан иргэд 1299(5.6%)-аар өсч, олгосон тэтгэвэр тэтгэмж 361.1(5.4%) сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

Нийгмийн халамжийн тэтгэвэрт 2019 оны 10 сард 1420 хүн хамрагдсан нь өмнөх оноос 57(12.8%)-ээр өсч, олгосон тэтгэвэрийн хэмжээ 242.5(12.8%) сая төгрөгөөр нэмэгджээ. Нийгмийн нөхцөлт мөнгөн тусламжийг 1099 иргэнд 707.3 сая төгрөг, онцгой тохиолдлын болон амжиргааг дэмжих мөнгөн тэтгэмжийг 1001 иргэнд 506.5 сая төгрөг тус тус олгож, нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа зайлшгүй шаардлагатай НХТХууль 3.1.2, 18.2-т заасан өрх, иргэнийг нийгэмшүүлэх, хамт олны бүлэг бүрдүүлэх, орлогын эх үүсвэртэй болгох төсөл хэрэгжүүлэх, амьдрах ухаанд сургахад 9403 иргэнийг хамруулж, 969.6 сая төгрөгийг зарцуулсан байна. Бусад төрлийн халамжийн үйлчилгээнд 11657 иргэн хамрагдаж, 4825.0 сая төгрөгийг олгожээ.

Зураг. Хүний тоо



Зураг. Олгосон тэтгэвэр, тэтгэмж /сая. төг/



## 1.6 Гэмт хэрэг

Аймгийн Цагдаагийн газраас ирүүлсэн мэдээгээр 2019 оны 10 дугаар сарын байдлаар 497 хэрэг бүртгэгдэж, гэмт хэргийн улмаас 184 хүн гэмтэж, 30 хүн нас барсан байна. Бүртгэгдсэн гэмт хэргийн тоо өмнөх оны мөн үеэс 66(15.3%)-аар, гэмтсэн хүний тоо 76(70.4%) -аар, нас барсан хүний тоо 13(76.5%)-аар нэмэгдсэн байна.

Бүртгэгдсэн гэмт хэргийг төрлөөр нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг 3(1.6%)-аар, хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг 4(11.1%)-өөр, улсын хилээр хууль бусаар эд зүйлс нэвтрүүлсэн гэмт хэрэг 7(31.8%)-аар, хүний эрүүл мэндэд хохирол учруулсан гэмт хэрэг 37 (33.0%)-оор, хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг 10(62.5%)-аар, хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэрэг 12(2.3 дахин)-аар, хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг 13(4.2 дахин)-аар өсч, олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг 4(44.4%)-өөр, нийтийн албаны ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг 9(64.3%)-өөр, үндэсний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг 14(87.5%)-өөр тус тус буурчээ.

Зураг. Бүртгэгдсэн гэмт хэргийн тоо, сараар






Нийт бүртгэгдсэн гэмт хэргийн 37.8 хувийг өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг, 30.0 хувийг хүний эрүүл мэндэд хохирол учруулсан гэмт хэрэг, 8.0 хувийг хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг, 5.8 хувийг улсын хилээр хууль бусаар эд зүйлс нэвтрүүлсэн гэмт хэрэг, 5.2 хувийг хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг, 3.4 хувийг хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг, 9.8 хувийг бусад төрлийн гэмт хэргүүд эзэлж байна. Сogтуугаар үйлдсэн гэмт хэрэг 143 бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 90(2.7 дахин)-ээр нэмэгдсэн байна.

Гэмт хэргийн тоо өмнөх оны мөн үеэс Даланжаргалан, Дэлгэрэх, Иххэт, Хөвсгөл, Эрдэнэ, Сайншанд, Замын-Үүд сумдад нэмэгдэж, Алтанширээ, Өргөн сумдад өмнө онтой адил, бусад сумдад гэмт хэргийн тоо буурсан байна.

Зураг. Бүртгэгдсэн гэмт хэргийн тоо, сумаар




Гэмт хэргийн улмаас иргэд, байгууллага, аж ахуйн нэгжид 2314.3 сая төгрөгийн хохирол учирсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 5364.0 (69.8%) сая төгрөгөөр буурсан байна. Учирсан хохирлын 1611.4 (69.6%) сая төгрөг эргэн төлөгдсөн байна.

Нийт гэмт хэргийн 170(34.2%) нь гэр орон сууцандаа, 143(28.8%) нь согтуугаар, 50 (10.1%) нь гудамж олон нийтийн газарт, 46(9.3%) бүлэглэн, 70(14.1%) хувийг эмэгтэй хүн, хүүхэд оролцон, 153 (30.8%) нь шөнийн цагаар /22-06 цаг/ үйлдсэн байна. Тайлант хугацаанд нийт 1274 хүн саатуулагдаж, 227 хүн баривчлагджээ.



Зураг. Бүртгээгдсэн гэмт хэргийн бүтэц, хэрэг үйлдэгдсэн цагаар 2019 оны 10 сард




### Хоёр. Макро эдийн засгийн статистикийн үзүүлэлт




#### 2.1 Мөнгө, банк

Монгол банкны мэдээгээр арилжааны банкуудын зээлдэгчийн тоо 35.3 мянга болж өмнөх оноос 7.7(27.9%) мянган хүнээр нэмэгдэж, нийт хадгаламж эзэмшигчийн тоо 70.3 мянга болж өмнөх оны мөн үеээс 5.2 хувиар өссөн байна.

Зураг. Хадгаламжийн үлдэгдэл, зээлийн өрийн үлдэгдэл, 2018-2019 он, сая.төг



Зураг. Хадгаламж эзэмшигч, зээлдэгчийн тоо, 2018- 2019 он, мян.хүн



Иргэдийн мөнгөн хадгаламж 116.2 тэрбум төгрөг болж нэг хадгаламж эзэмшигчид дунджаар 1653.1 мянган төгрөг, аймгийн нэг хүнд дундажаар 1670.0 мянган төгрөгийн хадгаламж ногдож байна. Хадгаламжийн үлдэгдэлийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 41.3 (55.2%) тэрбум төгрөгөөр өссөн байна.


Хугацаа хэтэрсэн зээлийн өрийн үлдэгдэл 2019 оны 10 дугаар сарын эцэст 4.7 тэр бум төгрөг болж, өмнөх сараас 0.5 (8.9%) тэр бум төгрөгөөр буурч, өмнөх оны мөн үеэс 2.2(91.2%) тэр бум төгрөгөөр өсчээ. Хугацаа хэтэрсэн зээлийн өрийн үлдэгдэл нийт зээлийн өрийн үлдэгдлийн 1.7 хувийг эзэлж, өмнөх сараас 0.1 пунктээр буурч, өмнөх оны мөн үеэс 0.4 пунктээр өсчээ.

Чанаргүй зээл 10 дугаар сарын эцэст 7419.1 сая төгрөг болж өмнөх сараас 109.3(1.5%) сая төгрөгөөр өсч, өмнөх оны мөн үеэс 501.3 (6.3%) сая төгрөгөөр буурсан байна. Чанаргүй зээл нийт зээлийн өрийн үлдэгдлийн 2.6 хувийг эзэлж, өмнөх оны мөн үеэс 1.4 пунктээр буурсан байна.

Зураг. Зээл төрлөөр, дүнд эзлэх хувиар, 2019. 10 сард




Зураг. Зээлдэгчийн тоо, зээлийн төрлөөр, 2019.10 сард



## 2.2 Төсөв, санхүү

2019 оны 10 сарын байдлаар орон нутгийн төсөвт 62777.4 сая төгрөгийн орлого төвлөрүүлжээ. Төсвийн орлогын төлөвлөгөөний биелэлт 104.5 хувь байна. Аймгийн орон нутгийн төсвийн орлогын 36.0 хувийг татварын, 17.3 хувийг татварын бус орлого, 46.7 хувийг улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлсэн орлого бүрдүүлсэн байна.

Зураг. Орон нутгийн төсвийн орлого, зарлагын бүтэц, хувиар, 2019 оны 10 сард



Улсын нэгдсэн төсөвт ААНБ-ын орлогын албан татвар, дотоодын бараа, үйлчилгээний татвар, ашигт малтмал нөөц ашигласны төлбөр, агаарын бохирдлын төлбөр нийт 7533.5 сая төгрөгийг төвлөрүүлсэн байна. Улсын төсөвт төвлөрүүлсэн орлогын дүнг өмнөх оны мөн үеэс 2948.4 (64.3%) сая.төг-өөр, төлөвлөгөөнөөс 3301.5 (78.0) сая.төг-өөр давуулан биелүүлсэн байна.



## 2.3 Үнэ

Хэрэглээний үнийн индекс гэдэг нь хэрэглэгчдийн худалдаж авсан бараа, үйлчилгээний нэр төрөл өөрчлөлтгүй тогтвортой байхад үнэ дунджаар хэрхэн өөрчлөгдөж буйг хэмждэг үзүүлэлт юм.

Хэрэглээний үнийн индекс 2019 оны 10 дугаар сарыг өмнөх сартай харьцуулахад 0.1 хувиар буурч, өмнөх оны мөн үеэс 6.3 хувиар өсчээ.


**Ерөнхий индекс өмнөх сартай харьцуулахад -0.1 хувиар буурахад:** хүнсний бараа, согтууруулах бус ундааны бүлэг 0.6 хувиар буурсан, бусад бараа үйлчилгээний бүлэг тогтвортой байна.

**Ерөнхий индекс өмнөх оны мөн үетэй харьцуулахад 6.3 хувиар өсөхөд:** хүнсний бараа, согтууруулах бус ундааны бүлэг 12.1 хувь, согтууруулах ундаа, тамхины бүлэг 3.5 хувь, хувцас бөс бараа, гуталын бүлэг 5.9 хувь, орон сууц, ус, цахилгаан, түлшний бүлэг 7.2 хувь, гэр ахуйн тавилгын бүлэг 3.6 хувь, эм тариа, эмнэлэгийн үйлчилгээний бүлэг 3.1 хувь, тээвэрийн бүлэг 1.8 хувь, амралт чөлөөт цаг соёлын барааны бүлэг 3.4 хувь, боловсролын үйлчилгээний бүлэг 9.9 хувь, зочид буудал, зоогийн газар, дотуур байрны үйлчилгээний бүлэг 9.2 хувь, бусад бараа үйлчилгээний үнэ 6.1 хувиар тус тус өссөн нь голлон нөлөөлсөн байна.


*Зураг. Хэрэглээний үнийн индекс, 2019 оны 10 дугаар сарын өөрчлөлт, бүлгээр, хувиар (өмнөх сар=100)*



Зураг. Хэрэглээний үнийн индекс, 2018-2019 оны үнийн өөрчлөлт, сар бүрээр (өмнөх сар=100)



Зураг. Хэрэглээний үнийн индекс, 2015 -2019 оны 10 дугаар сар (өмнөх оны 12-р сар=100)



### Гурав. Эдийн засгийн статистикийн үзүүлэлт



#### 3.1 Хөдөө аж ахуй


Аймгийн хэмжээнд 2018 оны эцэст тоологдсон төллөх насны нийт 929.6 мянган хээлтэгч малын 699.1 мянга (75.2%) нь 2019 оны эхний 10 сард төллөсөн байна. Эм хонины 82.2 хувь, эм ямааны 73.2 хувь, ингэний 42.5 хувь, үнээний 57.8 хувь, гүүний 53.5 хувь нь төллөжээ.

Гарсан төлийн 99.6 хувь буюу 701.1 мянган төл бойжиж байна. Бойжуулсан төл өмнөх оны мөн үеэс 101.9 (17.0%) мянгаар нэмэгдсэн байна. Даланжаргалан

суманд 73.4 мянга, Дэлгэрэх суманд 72.5 мянга, Айраг суманд 61.7 мянга, Өргөн суманд 57.9 мянга, Иххэт суманд 56.0 мянга, Алтанширээ суманд 53.6 мянга, Хатанбулаг суманд 53.1 мянган төл тус тус бойжсон нь нийт бойжсон төлийн 61.1 хувийг эзэлж байна.

Том малын зүй бус хорогдол 2019 оны эхний 10 сард аймгийн хэмжээнд 4540 болж, өмнөх оны мөн үеэс 5751 (55.9%) толгойгоор буурав. Нийт хорогдсон малын 56.9 хувийг ямаа, 36.3 хувийг хонь эзэлж байна.

*Зураг. Том малын зүй бусын хорогдол, жил бүрийн 10-р сард*



Малын зах зээлийн дундаж үнийн мэдээгээр нас гүйцсэн ат Алтанширээ суманд хамгийн их буюу 1500.0 мянган төгрөг, Дэлгэрэх суманд хамгийн бага буюу 700.0 мянган төгрөг, соёолон үрээ Мандах суманд их буюу 1100.0 мянган төгрөг, Сайхандулаан суманд хамгийн бага буюу 700.0 мянган төгрөг, хязаалан шар Алтанширээ, Иххэт, Эрдэнэ сумдад хамгийн их буюу 1500.0 мянган төгрөг, Дэлгэрэх суманд хамгийн бага буюу 900.0 мянган төгрөг байна. Нас гүйцсэн эр хонины дундаж үнэ Замын-үүд суманд хамгийн их буюу 200.0 мянган төгрөг, Иххэт суманд хамгийн бага буюу 120.0 мянган төгрөг, нас гүйцсэн эр ямааны дундаж үнэ Хатанбулаг, Замын-үүд сумдад хамгийн их буюу 150.0 мянган төгрөг, Алтанширээ, Иххэт сумдад хамгийн бага буюу 90.0 мянган төгрөг байна.



### 3.2 Аж үйлдвэр

Оны эхний 10 сарын байдлаар аж үйлдвэрийн салбарт 174855.0 сая төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, 281393.6 сая төгрөгийн бүтээгдэхүүнийг зах зээлд борлууллаа. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад нийт бүтээгдэхүүн үйлдвэрлэлт 5.6 хувиар буурч, борлуулалт 5.0 хувиар өссөн байна.

Аж үйлдвэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн 3.1 хувийг төрийн, 96.9 хувийг хувийн өмчийн аж ахуйн нэгжүүд үйлдвэрлэжээ.

Аж ахуйн нэгжийн хариуцлагын хэлбэрээр авч үзвэл улсын үйлдвэрийн газар 3.1 хувь, компани 96.5 хувь, өрхийн аж ахуй 0.4 хувийг тус тус эзэлж байна.

Статистикийн мэдээлэлд хамрагдсан гол нэр төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад дулаан 38.5 мян.ккалаар, ус

түгээлт 217.0 мян.м3-аар, сувагжуулалт 140.5 мян.м3-аар, савласан цэвэр ус 437.3 мян.литрээр, талх 25.7 тонноор, нарийн боов 50.7 тонноор, бялуу 0.8 тонноор, хиам 8.8 тонноор, сүүн бүтээгдэхүүн 11.8 мян.литрээр, хэрчсэн гурил 8.3 мян.тн-оор, банш бууз 3.4 тонноор, бетон зуурмаг 1500.1 мян.м3-аар, шохой 15.0 тонноор, цемент 28.5 мян.тонноор, дээл 104 ширхгээр, жижг оёдол 1273.6 мян.төгрөгөөр, хайрга 8.1 мян.м3-аар тус тус илүү үйлдвэрлэгджээ.



### 3.3 Барилга угсралт, их засвар

2019 оны эхний 10 сарын байдлаар нийт 106946.5 сая төгрөгийн шинэ барилга, өргөтгөл, шинэчлэлт, их засварын ажил хийсэн нь өмнөх онтой харьцуулахад 70.5 хувиар буурсан байна. Барилгын нийт хөрөнгө оруулалтын 16.8 хувийг улсын төсвийн, 6.8 хувийг орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар, үлдэх хувийг хөрөнгө оруулалтын бусад эх үүсвэрээр санхүүжүүлжээ.

Зураг. Барилга угсралт, их засварын ажил, төрлөөр, сая төг



Барилга угсралт их засварын ажлын 51.3 хувь нь инженерийн барилга, байгууламж, 11.6 хувь нь орон сууцны барилга, 32.9 хувь нь орон сууцны бус барилга, 4.2 хувь нь их засварын ажил байна. Өмнөх оны мөн үеийнхээс орон сууцны бус барилгынх 18.2 пункт, орон сууцны барилгын эзлэх хувь 7.0 пункт, их засварын ажлынх 3.3 пунктээр тус тус өсч, инженерийн барилга, байгууламжийн эзлэх хувь 28.4 пунктээр буурсан байна.





## Дөрөв. Байгаль орчны статистикийн үзүүлэлт



### 4.1 Байгаль орчин

#### Цаг уур

Сарын дундаж агаарын температур: 10 дугаар сард Мандах, Дэлгэрэх, Айраг, Иххэт сумдад 4.0-4.8 градус, бусад сумдын нутгаар 5.0-6.6 градус дулаан, агаарын хамгийн их температур өдөртөө нийт нутгаар 28-32 градус дулаан байлаа. Агаарын дундаж температурыг олон жилийн дундаж /ОЖД/-тай харьцуулахад: Эрдэнэ, Өргөн, Айраг, Алтанширээ, Иххэт сумдад ОЖД-аас дулаан, бусад сумдын нутгаар ОЖД-ийн орчим байлаа. Хөрсний гадарга дээр шөнөдөө 8-14 градус хүйтэн, өдөртөө нийт сумдын нутгаар 39-45 градус дулаан байв.

Хур тунадас: 10 дугаар сард нийт нутгаар 2-6 өдөр хур тунадас орж, сарын нийлбэр хамгийн их тунадас Хатанбулаг суманд 31.5 мм, Замын-Үүд, Улаанбадрах сумдад 21.7-21.9 мм, хамгийн бага нь Алтанширээ суманд 0.1 мм, Дэлгэрэх суманд 0.4 мм, бусад сумдын нутгаар 1.5-17.1 мм орлоо. Орсон хур тунадасны нийлбэрийг олон жилийн дундаж /ОЖД/-тай харьцуулахад: Сайхандулаан суманд ОЖД-ийн орчим, Сайншанд, Дэлгэрэх, Айраг, Алтанширээ сумдад ОЖД-аас бага, бусад сумдад ОЖД-аас ахиу байв.

Салхи: Энэ сард салхины хамгийн их хурд Айраг, Алтанширээ, Иххэт, Улаанбадрах сумдад секундэд 12-14 метр, бусад сумдад секундэд 16-23 метр хүрч аюултай болон онц аюултай үзэгдлийн хэмжээнд ажиглагдсан байна. 10 м/с-ээс дээш салхитай 3...20 өдөр байлаа.

Бэлчээрийн ургамал: 10 дугаар сарын сүүлийн арав хоногийн байдлаар ихэнх сумдын нутгаар бэлчээрийн ургамал хаталт хагдралтын үе шатанд орсон, бэлчээрийн ургац 0.1-0.6 ц/га байна.

\_\_\_\_\_ о О о \_\_\_\_\_

**ДОРНОГОВЬ АЙМГИЙН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН БАЙДАЛ**  
( 2019 ОНЫ 10 ДУГААР САРЫН БАЙДЛААР )**I. Эдийн засаг, нийгмийн үндсэн үзүүлэлтүүд**

	Хэмжих нэгж	2016	2017	2018	2019	2019 2018
1. Бэлэн хүн ам, мян.хүн *	мянган хүн	1205	1078	1139	70.3	6.2
- Төрсөн хүүхдийн тоо**	тоо	1297	1205	1078	1139	105.7
- Нас барсан хүний тоо - бодит тоогоор**	тоо	275	304	289	330	114.2
- Хүн амын цэвэр өсөлт - бодит тоогоор	тоо	1022	901	789	809	102.5
- Нялхасын эндэгдэл - бодит тоогоор	тоо	9	6	13	7	53.8
- 1000 хүүхдэд ноогдох	тоо	6.9	5.0	12.1	6.1	51.0
2. Ажилгүй иргэдийн тоо - бүгд	тоо	1 055	1 705	734	533	72.6
- Үүнээс эмэгтэй	тоо	561	841	337	258	76.6
- Хөдөлмөрийн насны 10000 хүнд ногдох ажилгүй иргэдийн тоо	тоо	265	374	153	115	74.9
3. Шинээр бий болсон ажлын байр-бүгд	тоо	284	302	213	325	152.6
Үүнээс: Байнгын ажлын байр	тоо	148	302	87	200	229.9
Улирлын чанартай ажлын байр	тоо	112	0	126	125	99.2
4. Халдварт өвчний гаралт - бодит тоогоор	тоо	1470	532	484	692	143.0
- 10000 хүнд ногдох	тоо	221	78	70	99	142.5
5. Гэмт хэргийн гаралт - бодит тоогоор	тоо	546	589	431	497	115.3
- 10000 хүнд ногдох ***	тоо	128	137	97	112	115.3
6.Бойжиж буй төл	толгой	469517	586705	599281	701158	117.0
- Унага	толгой	12817	21649	21919	24267	110.7
- Тугал	толгой	12753	16615	18153	18366	101.2
- Ботго	толгой	6005	6668	6835	7195	105.3
- Хурга	толгой	236632	286903	294822	345708	117.3
- Ишиг	толгой	201310	254870	257552	305622	118.7
6. Аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүн	сая төгрөг	9249.1	89580.5	134240.4	130982.6	97.6
- Борлуулсан бүтээгдэхүүн	сая төгрөг	6242.1	145349.5	196299.4	217145.5	110.6

\* - 2016,2017,2018 оны жилийн эцэст

\*\*-Төрөлт, нас баралтыг ЭМГ-ын мэдээнээс авав.

\*\*\* - 18 - аас дээш насны 10000 хүнд ногдохоор тооцов.



## НЭГ. ЭРҮҮЛ МЭНД

## 1.1 ЭРҮҮЛ МЭНДИЙН ГОЛ ҮЗҮҮЛЭЛТ

	Хэмжих нэгж	2018 I-X	2019 I-X	Өсөлт	
		Тоо		Хувь	
1. Амбулаторийн үзлэг	мян.хүн	299.3	336.9	37.6	112.6
2. Ор хоног	мян.хүн	99.0	100.0	1.0	101.0
3. Урьдчилан сэргийлэх тарилга	мян.хүн	11.2	11.4	0.2	101.8
4. Эмчлүүлсэн хүний тоо	мян.хүн	13.8	14.0	0.2	101.4
5. Түргэн тусламжын дуудлага	мян.хүн	16.3	16.2	-0.1	99.4
Үүнээс: алсын дуудлага	мян.хүн	2.7	2.5	-0.2	92.6
6. Осол гэмтлийн өвчлөл	хүн	2620	2850	230	108.8
Үүнээс: нас баралт	хүн	81	74	-7	91.4
7. Шинээр хяналтанд авсан жирэмсэн эх	хүн	1344	1537	193	114.4
Үүнээс: эхний 3 сартайн хяналт	хүн	1197	1369	172	114.4
8. Амаржсан эх	хүн	1134	1096	-38	96.6
Үүнээс: нас баралт	хүн	0	0	0	0.0
9. 1-5 хүртэл насны эндсэн хүүхэд	хүн	4	6	2	150.0
10. 1 хүртэл насандаа эндсэн хүүхэд	хүн	13	7	-6	53.8

## 1.2. ТӨРӨЛТ, ЭХ, ХҮҮХДИЙН ЭНДЭГДЭЛ, сумаар, жил бүрийн 10 сард

Сумын нэр	Амаржсан эх	Эхийн эндэгдэл	Амьд төрсөн хүүхэд	1 хүртэл насандаа эндсэн хүүхэд	1-5 хүртэл насны эндсэн хүүхэд
				Тоо	Тоо
Дүн	1096	0	1100	6	4
Айраг	1		1		1
Алтанширээ					
Даланжаргалан	2		2		
Дэлгэрэх					
Иххэт					
Мандах					
Өргөн	2		2		3
Сайхандулаан	1				
Улаанбадрах					
Хатанбулаг	3		3	1	
Хөвсгөл	2		2		
Эрдэнэ	2		2		
Сайншанд	868		874	5	
Замын - Үүд	215		214		

Эх үүсвэр: Аймгийн Эрүүл мэндийн газар



## 1.3. БҮРТГЭГДСЭН ХАЛДВАРТ ӨВЧИН, төрлөөр, жил бүрийн 10 сард

Үзүүлэлт	2018 I-X	2019 I-X	Өсөлт	
	Тоо	Тоо	Тоо	Хувь
Халдварт өвчний гаралт-Бүгд	587	865	278	147.4
Вируст гепатит	8	6	-2	75.0
Сүрьеэ	83	70	-13	84.3
Тэмбүү	107	167	60	156.1
Заг хүйтэн	164	269	105	164.0
Трихоминиаз	70	144	74	205.7
Цусан суулга	53	36	-17	67.9
Бусад	102	173	71	169.6

Тайлбар -<sup>2</sup>-дахин их

Эх үүсвэр: Эрүүл мэндийн газар



## ХОЁР. ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ

## 2.1 БҮРТГҮҮЛСЭН АЖИЛГҮЙ ИРГЭДИЙН ТОО, боловсролын түвшингээр, жил бүрийн 10 сард

Боловсролын түвшингээр	2016 X	2017 X	2018 X	2019 X	2019 X	2019 X
	хүний тоо				хувь	
	2016 X	2017 X	2018 X	2019 X	2016 X	2018 X
ДҮН	1 047	1 312	1 016	533	50.9	52.5
Үүнээс: Эмэгтэй	552	660	491	258	46.7	52.5
Магистр, доктор	8	7	1	1	12.5	0.0
Дээд боловсролтой	289	309	170	62	21.5	36.5
Тусгай дунд	110	96	33	12	10.9	36.4
Техник мэргэжлийн	122	106	63	12	9.8	19.0
Бүрэн дунд	373	682	643	395	105.9	61.4
Бүрэн бус дунд	115	80	66	34	29.6	51.5
Бага	20	13	11	4	20.0	36.4
Боловсролгүй	10	19	29	13	130.0	44.8

## 2.2 АЖИЛГҮЙ ИРГЭДИЙН ТОО, сумаар, жил бүрийн 10 сард

	Ажилгүй иргэдийн тоо		Ажилд орсон хүний тоо		Шинээр бүртгүүлсэн хүний тоо	
	2018 X	2019 X	2018 I-X	2019 I-X	2018 I-X	2019 I-X
ДҮН	1016	533	804	459	4506	176
Айраг	17	7	402	2	2253	1
Алтанширээ	36	10		35	94	1
Даланжаргалан	72	28	37	35	160	0
Дэлгэрэх	15	6	4	5	30	0
Иххэт	29	7	29	2	281	0
Мандах	16	6	71	6	113	0
Өргөн	23	13	26	86	108	1
Сайхандулаан	33	19	5	19	699	3
Улаанбадрах	16	18	46	31	41	4
Хатанбулаг	21	8	18	25	96	0
Хөвсгөл	9	7	16	15	66	4
Эрдэнэ	30	35	9	22	30	2
Сайншанд	560	252	98	94	410	125
Замын - Үүд	139	117	43	82	125	35

Эх үүсвэр: Хөдөлмөр, халамж үйлчилгээний газар



## 2.3 АЖЛЫН БАЙРНЫ ЗАХИАЛГА, эдийн засгийн салбарын ангилал, 2019 оны 10 сарын эцэст

Салбарын ангилал	2018 I-X	2019 I-X
	Тоо	
Бүгд	617	516
ХАА, ан агнуур, ойн аж ахуй,загас барилт	10	37
Уул уурхай олборлох аж үйлдвэр	199	173
Боловсруулах үйлдвэрлэл	7	1
Цахилгаан, хий, уур, агааржуулалт	6	9
Усны хангамж, бохир ус зайлуулах систем, хог хаягдлын	9	12
Барилга	61	59
Бөөний ба жижиглэн худалдаа, машин, мотоциклийн засвар	1	
Тээвэр агуулахын үйл ажиллагаа	17	7
Зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээ	1	2
Мэдээлэл, холбоо		
Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа	15	8
Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа		
Мэргэжлийн шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа		
Удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа	3	
Төрийн удирдлага, батлан хамгаалах, үйл ажиллагаа, албан	58	50
Боловсрол	33	43
Хүний эрүүл мэнд, нийгмийн халамжийн үйлчилгээ	30	9
Урлаг, үзвэр,тоглоом наадам	11	1
Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	155	105
Хүн хөлслөн ажиллуулдаг өрхийн үйл ажиллагаа,өрхийн өөрийн		
Олон улсын байгууллага, суурин төлөөлөгчийн үйл ажиллагаа	1	

## 2.4 АЖЛЫН БАЙРНЫ ЗАХИАЛГА, ажил, мэргэжлийн ангилал, 2019 оны 10 сарын эцэст

Үзүүлэлт	2018 I-X	2019 I-X
	Тоо	
Бүгд	617	516
Менежер	11	10
Мэргэжилтэн	119	60
Техникч болон туслах дэд/ мэргэжилтэн	68	71
Контор, үйлчилгээний ажилтан	19	26
Худалдаа, үйлчилгээний ажилтан	56	24
ХАА, ой загас агнуурын ажилтан	3	15
Үйлдвэрлэл, барилга,гар урлал,холбогдох ажил үйлчилгээний ажилтан	32	54
Суурин төхөөрөмж, машин механизмын операторч, угсрагч	87	70
Энгийн ажил мэргэжил	210	179
Зэвсэгт хүчний ажил мэргэжил	12	7

Эх үүсвэр: Хөдөлмөр, халамж үйлчилгээний газар



## 2.5 АЖИЛД ЗУУЧИЛСАН ИРГЭД, ажил, мэргэжлийн ангиллаар жил бүрийн 10 сард

Үзүүлэлт	2018 I-X		2019 I-X	
	Бүгд	эмэгтэй	Бүгд	эмэгтэй
	Тоо		Тоо	
Бүгд	538	226	459	177
Менежер	11	7	8	6
Мэргэжилтэн	76	52	58	44
Техникч болон туслах дэд/мэргэжилтэн	54	30	66	28
Контор, үйлчилгээний ажилтан	32	18	23	21
Худалдаа, үйлчилгээний ажилтан	56	41	20	17
ХАА, ой загас агнуурын ажилтан	1		15	5
Үйлдвэрлэл, барилга, гар урлал, холбогдох ажил үйлчилгээний	29	8	37	4
Суурин төхөөрөмж, машин механизмын операторч, угсрагч	72	11	65	4
Энгийн ажил мэргэжил	196	55	161	43
Зэвсэгт хүчний ажил мэргэжил	11	4	6	5

## 2.6 ШИНЭ АЖЛЫН БАЙРАНД ОРСОН ИРГЭН, эдийн засгийн салбарын ангиллаар 2019 оны 10 сард

Салбарын ангилал	Бүгд	Эмэгтэй	Бүгдээс: Ажлын байрны шинж, чанараар	
			Байнга	Улирал
	Тоо			
Бүгд	325	105	200	125
ХАА, ан агнуур, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур	103	32	66	37
Уул уурхай олборлолт	2		2	
Боловсруулах үйлдвэрлэл	29	16	29	
Цахилгаан, хий уур агааржуулалтын хангамж				
Усан хангамж, бохир ус, хог хаягдлын менежмент				
Барилга	56	6	20	36
Бөөний ба жижиглэн худалдаа, гэр ахуйн барааны засварлах үйлчилгээ	29	4	21	8
Тээвэр агуулахын үйл ажиллагаа	3	2	3	
Байр сууц болон хоол хүнсээр үйлчлэх үйл ажиллагаа	23	13	12	11
Мэдээлэл холбоо	1		1	
Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа	1	1	1	
Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа				
Мэргэжлийн шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа	25	16	24	1
Захиргааны болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа	1		1	
Төрийн удирдлага, батлан хамгаалах, албан журмын даатгал	36	2	4	32
Боловсрол	7	5	7	
Хүний эрүүл мэнд ба нийгмийн үйл ажиллагаа	1	1	1	
Урлаг үзвэр тоглоом наадам				
Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	8	7	8	
Хүн хөлслөн ажиллуулдаг өрхийн аж ахуй				
Олон улсын байгууллагын үйл ажиллагаа				

Эх үүсвэр: Хөдөлмөр, халамж үйлчилгээний газар



## ГУРАВ. НИЙГМИЙН ДААТГАЛ, ХАЛАМЖ

## 3.1 НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ОРЛОГО, ЗАРЛАГА, ТӨРЛӨӨР, ЖИЛ БҮРИЙН 10 САРД

Үзүүлэлт	2018 I-X	2019 I-X	2019 I-X 2018 I-X
	сая төгрөг		хувь
Нийгмийн даатгалын сангийн орлого	26 667.9	33 849.3	126.9
Тэтгэврийн даатгалын сан	16 782.2	21 382.1	127.4
Тэтгэмжийн даатгалын сан	1 902.8	2 423.8	127.4
Эрүүл мэндийн даатгалын сан	4 428.4	5 521.1	124.7
ҮОМШӨ*-ний даатгалын сан	2 782.6	3 541.5	127.3
Ажилгүйдлийн даатгалын сан	771.9	980.8	127.1
Нийгмийн даатгалын сангийн зарлага	37 194.8	41 677.1	112.1
Тэтгэврийн даатгалын сан	26 949.8	31 210.8	115.8
Тэтгэмжийн даатгалын сан	2 111.9	2 466.3	116.8
Эрүүл мэндийн даатгалын сан	5 417.4	4 689.2	86.6
ҮОМШӨ*-ний даатгалын сан	2 022.3	2 409.6	119.2
Ажилгүйдлийн даатгалын сан	693.4	901.2	130.0

## 3.2 НИЙГМИЙН ДААТГАЛД ДААТГУУЛАГЧИД, ОЛГОСОН ТЭТГЭВРИЙН ХЭМЖЭЭ, ТӨРЛӨӨР, ЖИЛ БҮРИЙН 10 САРД

Үзүүлэлт	2018 I-X	2019 I-X	2019 I-X 2018 I-X
	хүн		хувь
1. Нийгмийн даатгалд даатгуулагчид	22230	22685	102.0
Албан журмаар даатгуулагчид	18267	18673	102.2
Аж ахуй нэгж, байгууллага	9531	9921	104.1
Төсөвт байгууллага	8736	8752	100.2
Сайн дураар даатгуулагчид	3963	4012	101.2
2. Тэтгэвэр авагчдын тоо	8187	8740	106.8
Өндөр насны тэтгэвэр	5948	6249	105.1
Хөгжлийн бэршээлтэй иргэдийн	1245	1315	105.6
Тэжээгчээ алдсаны	527	507	96.2
Цэргийн тэтгэвэр	427	463	108.4
ҮОМШӨ*-ний	200	206	103.0
	сая төгрөг		
3. Олгосон тэтгэвэр	27 631.8	31 794.1	115.1
Өндөр насны тэтгэвэр	19 989.7	23 096.3	115.5
Хөгжлийн бэршээлтэй иргэдийн	3 075.7	3 673.1	119.4
Тэжээгчээ алдсаны	1 444.1	1 491.3	103.3
Цэргийн тэтгэвэр	2 402.1	2 818.8	117.3
ҮОМШӨ*-ний	720.2	714.6	99.2

Тайлбар: \*-Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчин

Эх үүсвэр: Нийгмийн даатгалын хэлтэс





## 3.3 НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ОРЛОГО, сумаар

Сумын нэр	2018 I-X	2019 I-X	2019 I-X 2018 I-X
	сая төгрөг		хувь
ДҮН	26667.9	33849.3	126.9
Айраг	479.4	597.0	124.5
Алтанширээ	159.6	209.3	131.1
Даланжаргалан	1232.6	1504.5	122.1
Дэлгэрэх	192.3	243.8	126.8
Иххэт	255.2	454.5	178.1
Мандах	343.8	274.6	79.9
Өргөн	867.6	1177.0	135.7
Сайхандулаан	197.3	269.0	136.3
Улаанбадрах	203.4	265.2	130.4
Хатанбулаг	480.5	848.5	176.6
Хөвсгөл	202.5	254.7	125.8
Эрдэнэ	366.9	495.5	135.1
Сайншанд	14811.2	18686.8	126.2
Зүүнбаян баг	799.7	1025.3	128.2
Замын-Үүд	6075.9	7543.6	124.2

## 3.4 НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ЗАРЛАГА, сумаар

Сумын нэр	2018 I-X	2019 I-X	2019 I-X 2018 I-X
	сая төгрөг		хувь
ДҮН	37194.8	41677.1	112.1
Айраг	1848.7	2063.2	111.6
Алтанширээ	714.0	783.6	109.7
Даланжаргалан	1514.8	1857.7	122.6
Дэлгэрэх	756.5	870.1	115.0
Иххэт	1335.4	1491.5	111.7
Мандах	833.5	887.0	106.4
Өргөн	1416.0	1558.4	110.1
Сайхандулаан	536.0	598.1	111.6
Улаанбадрах	812.2	937.0	115.4
Хатанбулаг	1377.7	1621.8	117.7
Хөвсгөл	699.8	764.4	109.2
Эрдэнэ	1227.5	1418.0	115.5
Сайншанд	16056.3	17468.9	108.8
Зүүнбаян баг	1434.3	1553.3	108.3
Замын-Үүд	6632.1	7804.1	117.7



## 3.5 НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭНД ХАМРАГДСАН ХҮНИЙ ТОО, ОЛГОСОН ТЭТГЭВЭР, ТЭТГЭМЖИЙН ХЭМЖЭЭ, төрлөөр, жил бүрийн 10 сарын эцэст

Үзүүлэлт	Хамрагдсан хүний тоо		2019 I-X 2018 I-X	Олгосон тэтгэвэр тэтгэмж		2019 I-X 2018 I-X
	2018 I-X	2019 I-X		2018 I-X	2019 I-X	
	тоо		хувь	сая төгрөг		хувь
<b>НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН САНГИЙН ЗАРЦУУЛАЛТ</b>	<b>23281</b>	<b>24580</b>	<b>105.6</b>	<b>6647.0</b>	<b>7008.1</b>	<b>105.4</b>
<b>1. Халамжийн тэтгэвэр</b>	<b>1363</b>	<b>1420</b>	<b>104.2</b>	<b>1897.5</b>	<b>2140.0</b>	<b>112.8</b>
Ахмад настны тэтгэвэр	61	86	141.0	83.7	119.2	142.4
Хөгжлийн бэрхшээлтэй иргэний тэтгэвэр	1302	1334	102.5	1813.8	2020.8	111.4
<b>2 Нөхцөлт мөнгөн тэтгэмж</b>	<b>1069</b>	<b>1099</b>	<b>102.8</b>	<b>631.7</b>	<b>707.3</b>	<b>112.0</b>
Эмнэлгийн хяналтад байдаг, байнгын асаргаа шаардлагатай, ахмад настан болон хөгжлийн бэрхшээлтэй хүнийг асарч байгаагийн улмаас хөдөлмөр эрхлэдэггүй хөдөлмөрийн насны иргэнд олгосон тэтгэмж	1006	1039	103.3	590.8	665.3	20.5
Бүтэн өнчин хүүхдийг үрчлэн авсан болон асран хамгаалж харгазан дэмжиж байгаа иргэнд олгох тэтгэмж	51	51	100.0	33.6	36.0	107.1
Гэр бүлийн тухай хуулийн 25.5-д заасан болон хүчирхийллийн улмаас хамгаалалт шаардлагатай болсон хүүхдийг мөн хуулийн 74 дүгээр зүйлд заасны дагуу гэр бүлдээ авч асрамжилж байгаа иргэнд олгох тэтгэмж	6	7	116.7	4.9	4.5	91.8
Ахмад настаныг гэртээ асрамжилж байгаа иргэн	5	2	40.0	1.8	1.5	83.3
Байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй иргэн	1			0.6	0.0	0.0
<b>3. Онцгой тохиолдлын болон амжиргааг дэмжих мөнгөн тэтгэмжийн дүн</b>	<b>1010</b>	<b>1001</b>	<b>99.1</b>	<b>523.7</b>	<b>506.5</b>	<b>536.1</b>
16 хүртэлх насны байнгын асаргаа шаардлагатай хүүхдэд олгох мөнгөн тэтгэмж	234	232	99.1	319.2	322.4	101.0
Байнгын асаргаа шаардлагатай 16-с дээш насны иргэн	711	705	99.2	118.9	99.3	83.5
Гурав ба түүнээс дээш тооны бага насны /14 хүртэлх насны/ хүүхэдтэй өрх толгойлсон эх /эцэг/	4			0.4	0.0	
2 ихэр хүүхэд төрүүлж эсэн мэнд өсгөж байгаа өрх, иргэнд олгох тэтгэмж	15	10	66.7	30.0	16.0	53.3



## Хүснэгт 3.5-ийн үргэлжлэл

Үзүүлэлт	Хамрагдсан хүний тоо		2019 I-X 2018 I-X	Олгосон тэтгэвэр тэтгэмж		2019 I-X 2018 I-X
	2018 I-X	2019 I-X		2018 I-X	2019 I-X	
	тоо		хувь	мянган төгрөг		хувь
18 нас хүрээгүй байхдаа бүтэн өнчин болсон 18-24 насны иргэн	12	7	58.3	14.4	12.4	86.1
Гэнэтийн аюул, ослын улмаас орон гэргүй болсон өрх	20	41	205.0	24.0	49.2	205.0
Хорих ангиас суллагдсан өөрийн гэр оронгүй иргэн	14	1	7.1	16.8	1.2	7.1
Нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа зайлшгүй шаардлагатай, 4 ба түүнээс дээш 18 хүртэлх насны хүүхэдтэй, гэр оронгүй, өрх толгойлсон иргэн		5			6.0	
<b>4. Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээний зардал</b>	<b>0</b>	<b>0</b>		<b>0</b>	<b>0</b>	
<b>5. Нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа зайлшгүй шаардлагатай НХТХууль 3.1.2, 18.2-т заасан өрх, иргэнийг нийгэмшүүлэх, хамт олны бүлэг бүрдүүлэх, орлогын эх үүсвэртэй болгох төсөл хэрэгжүүлэх, амьдрах ухаанд сургах зардал</b>	<b>8621</b>	<b>9403</b>	<b>109.1</b>	<b>916.1</b>	<b>969.6</b>	<b>105.8</b>
Ахмад настанд үзүүлсэн тусламж, хөнгөлөлтийн зарцуулалт	3998	3860	96.5	298.1	300.4	100.8
Хөгжлийн бэрхшээлтэй иргэний тусламж, хөнгөлөлт	370	197	53.2	83.0	87.6	105.5
Амьжиргааг дэмжих зөвлөлийн гишүүн, сум, хорооны нийгмийн ажилтанд олгох урамшил	0	105	0.0	6.9	4.9	71.0
Хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээний зарцуулалт	2896	3682	127.1	316.1	370.6	117.2
Банкны шимтгэл				3.5	3.9	111.4
Жирэмсэн болон нярай, хөхүүл хүүхэдтэй эхийн тэтгэмжийн зарцуулалт	1357	1559	114.9	208.5	202.2	97.0
<b>6. Бусад халамжийн дүн</b>	<b>11218</b>	<b>11657</b>	<b>103.9</b>	<b>2678.0</b>	<b>2684.7</b>	<b>100.3</b>
Алдарт эхийн одонгийн тусламж	4898	4985	101.8	652.9	660.4	101.1
Алдар цолтой ахмадуудад үзүүлсэн хөнгөлөлт, тусламж	18	20	111.1	30.1	29.9	99.3
Цалинтай ээж хөтөлбөр	3769	3894	103.3	1500.1	1424.6	95.0
Насны хишгийн зардал	2378	2552	107.3	379.3	407.2	107.4
Өрх толгойлсон эх/эцэг хөтөлбөрийн зардал	155	206	132.9	115.6	162.6	140.7

Эх үүсвэр: Хөдөлмөр, халамж үйлчилгээний газар



## ДӨРӨВ. ГЭМТ ХЭРЭГ

## 4.1 БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРГИЙН ТОО, төрлөөр, жил бүрийн 10 сард

Хэргийн төрөл	2018 I-X	2019 I-X	зөрүү	Хэргийн бүтэц	
				2018 I-X	2019 I-X
	тоо	хувь			
<b>Бүртгэгдсэн гэмт хэрэг - ДҮН</b>	431	497	66	100.0	100.0
Хүн амьд явах эрхийн эсрэг гэмт хэрэг	9	21	12	2.1	4.2
Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг	16	26	10	3.7	5.2
Хүний эрүүл мэндэд хохирол учруулсан гэмт хэрэг	112	149	37	26.0	30.0
Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг	185	188	3	42.9	37.8
Хулгайлах	96	91	-5	22.3	18.3
Залилах	28	34	6	6.5	6.8
Гээгдэл эд зүйл ашиглах	12	10	-2	2.8	2.0
Хөрөнгө завших	12	21	9	2.8	4.2
Бусдын эд хөрөнгө устгах, гэмтээх, үрэгдүүлэх	1	0	-1	0.2	0.0
үүнээс: Эд хөрөнгө устгах, гэмтээх	4	8	4	0.9	1.6
Дээрэмдэх	6	4	-2	1.4	0.8
Бусдын эд хөрөнгийг авахаар	1	0	-1	0.2	0.0
Автотээврийн хэрэгслийг зөвшөөрөлгүйгээр авч явах	0	1	1	0.0	0.2
Мал хулгайлах	25	19	-6	5.8	3.8
Улсын хилээр хууль бусаар эд зүйлс нэвтрүүлсэн	22	29	7	5.1	5.8
Авилгын гэмт хэрэг	4	6	2	0.9	1.2
Олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг	9	5	-4	2.1	1.0
Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны эсрэг	4	0	-4	0.9	0.0
Нийтийн албаны ашиг сонирхлын эсрэг	14	5	-9	3.2	1.0
Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг	4	17	13	0.9	3.4
Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг	36	40	4	8.4	8.0
Үндэсний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг	16	2	-14	3.7	0.4
Цэргийн албаны эсрэг гэмт хэрэг	0	1	1	0.0	0.2
Цахим мэдээллийн аюулгүй байдлын эсрэг	0	3	3	0.0	0.6
эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг	0	2	2	0.0	0.4
Бусад гэмт хэрэг	0	3	3	0.0	0.6
согтуугаар үйлдсэн	53	143	90	12.3	28.8
Гэмт гудамж, талбай	68	50	-18	15.8	10.1
хэргийн гэр орон сууцанд	114	170	56	26.5	34.2
тоо бүлэглэн үйлдсэн	20	46	26	4.6	9.3
хүүхэд оролцсон	5	11	6	1.2	2.2
эмэгтэй хүн оролцсон	56	59	3	13.0	11.9
Гэмт 06.00 -14.00	130	152	22	30.2	30.6
хэрэг 14.00-19.00	99	120	21	23.0	24.1
үйлдсэн 19.00 - 22.00	56	72	16	13.0	14.5
цаг 22.00 - 06.00	146	153	7	33.9	30.8
Гэмт хэргийн нас барсан хүний тоо	17	30	13		
улмаас гэмтэж бэртсэн хүний тоо	108	184	76		

Эх үүсвэр: Аймгийн Цагдаагийн газар



## 4.2 БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРГИЙН ТОО , сумаар

	2018 I-X	2019 I-X	Үүнээс: хэргийн төрлөөр						Бусад
